

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/24/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Ankhubayard@audit.gov.mn">Ankhubayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Enkhturb@audit.gov.mn">Enkhturb@audit.gov.mn</a></p>
--	---

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 77

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

АЙМГИЙН СПОРТЫН ТӨРӨЛЖСӨН  
СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.НАРАНБАТ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot


006070176

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4foot

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

#### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>41,997,455.56</u></b>	<b><u>53,696,888.96</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	1,637,004.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	105,864.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	1,531,140.00
3351	Байгууллагаас авах авлага	-	407,340.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	1,123,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	41,997,455.56	52,059,884.96
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,276,089.66	28,233,489.66
35110	Тусгай зориулалттай материал	19,179,039.66	27,284,239.66
35130	Эм боох материал	97,050.00	949,250.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,721,365.90	23,826,395.30
35410	Бичиг хэргийн материал	307,000.00	420,000.00
35420	Аж ахуйн материал	18,575,234.80	18,488,834.80
35450	Барилгын засварын материал	999,590.50	1,284,690.50
35460	Хүнсний материал	2,637,340.60	2,724,770.00
35470	Бусад хангамжийн материал	60,200.00	908,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,105,199,027.48</u></b>	<b><u>1,070,690,163.90</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,105,199,027.48	1,070,690,163.90
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,068,354,027.91	1,033,912,664.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,036,876,227.90	1,036,876,227.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,959,714.60)	(80,272,905.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,589,602.78	76,903,902.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,518,370.36)	(54,277,267.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,994,132.00	23,844,132.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,346,815.57)	(19,579,418.69)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,966,290.73	61,966,290.73
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,841,045.72)	(13,234,068.60)
39217	Ном	1,593,720.75	1,685,770.55
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,844,999.57	36,777,499.57
39301	Программ хангамж	3,040,000.00	3,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,595,000.43)	(1,662,500.43)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,400,000.00	35,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,147,196,483.04</u></b>	<b><u>1,124,387,052.86</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,147,196,483.04</u></b>	<b><u>1,124,387,052.86</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,147,196,483.04	1,124,387,052.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	702,221,899.34	702,221,899.34
51101	Өмч: - төрийн	35,400,000.00	35,400,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(190,257,894.54)	(213,067,324.72)
51210	Өмнөх үеийн үр дүн	(190,257,894.54)	(190,257,894.54)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,809,430.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	635,232,478.24	635,232,478.24
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,147,196,483.04</u></b>	<b><u>1,124,387,052.86</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

#### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

**Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>439,057,678.91</b>	<b>446,464,445.80</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>17,754,526.91</b>	<b>6,136,549.80</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	17,754,526.91	6,136,549.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,754,526.91	6,136,549.80
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		942,049.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		5,194,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>421,303,152.00</b>	<b>440,327,896.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	353,903,800.00	356,406,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,903,800.00	356,406,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,371,396.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	371,396.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	63,813,000.00	81,550,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,813,000.00	81,550,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>450,123,105.72</b>	<b>469,273,875.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>450,123,105.72</b>	<b>469,273,875.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	427,117,700.94	455,270,120.33
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	248,488,088.02	269,501,393.84
210101	Үндсэн цалин	177,527,510.79	194,928,819.99
210102	Нэмэгдэл	40,409,008.77	51,133,775.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,317,250.00	9,884,261.35
210104	Урамшуулал	21,234,318.46	13,554,536.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,272,341.20	35,253,554.51
210201	Тэтгэврийн даатгал	20,495,035.13	26,322,633.99
210202	Тэтгэмжийн даатгал	2,431,587.26	2,375,127.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,576,120.45	1,839,321.83
210204	Ажилгүйдлийн даатгал	439,993.59	379,784.18
210205	Эрүүл мэндийн даатгал	5,329,604.77	4,336,687.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,865,991.00	70,550,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,185,971.00	2,012,960.00
210302	Түлш, халаалт	58,080,990.00	63,784,890.00
210303	Цэвэр, бохир ус	2,599,030.00	4,752,650.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,906,055.00	3,530,938.00
210401	Бичиг хэрэг	320,600.00	366,896.00
210402	Тээвэр, шатахуун	826,800.00	1,045,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	243,915.00	593,542.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,499,860.00	387,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,634,750.00	1,137,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	11,030,177.40	14,928,770.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	60,000.00	182,900.00
210502	Хоол, хүнс	9,689,677.40	14,243,370.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,280,500.00	502,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,808,560.00	12,062,650.00
210604	Урсгал засвар	1,773,310.00	12,062,650.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	300,000.00	348,700.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	348,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	57,810,388.32	49,093,613.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,596,000.00	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,061,690.00	328,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,152,698.32	47,765,213.38
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,005,404.78	14,003,755.65
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	22,408,395.78	13,703,755.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,408,395.78	13,703,755.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(11,065,426.81)</b>	<b>(22,809,430.18)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(14,944,453.11)</b>	<b>(22,809,430.18)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(190,257,894.54)	-	1,147,196,483.04
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(190,257,894.54)	-	1,147,196,483.04
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(190,257,894.54)	-	1,147,196,483.04
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,809,430.18)	-	(22,809,430.18)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	702,221,899.34	635,232,478.24	(213,067,324.72)	-	1,124,387,052.86

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>417,716,800.00</b>	<b>440,327,896.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>417,716,800.00</b>	<b>440,327,896.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	353,903,800.00	356,406,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,903,800.00	356,406,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,371,396.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	371,396.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	63,813,000.00	81,550,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,813,000.00	81,550,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>412,166,800.00</b>	<b>428,013,596.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>412,166,800.00</b>	<b>428,013,596.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>389,161,395.22</b>	<b>414,009,840.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	248,488,088.02	269,607,257.40
210101	Үндсэн цалин	177,527,510.79	195,034,683.11
210102	Нэмэгдэл	40,409,008.77	51,133,775.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,317,250.00	9,884,261.79
210104	Урамшуулал	21,234,318.46	13,554,536.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,272,341.20	35,253,554.95
210201	Тэтгэврийн даатгал	20,495,035.13	24,968,821.99
210202	Тэтгэмжийн даатгал	2,431,587.26	2,652,538.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,576,120.45	2,118,365.35
210204	Ажилгүйдлийн даатгал	439,993.59	484,488.40
210205	Эрүүл мэндийн даатгал	5,329,604.77	5,029,340.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	61,865,991.00	70,550,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,185,971.00	3,400,000.00
210302	Түлш, халаалт	58,080,990.00	62,397,850.00
210303	Цэвэр, бохир ус	2,599,030.00	4,752,650.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,017,775.00	7,595,338.00
210401	Бичиг хэрэг	299,300.00	110,096.00
210402	Тээвэр, шатахуун	968,800.00	662,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	369,915.00	593,542.00
210404	Ном, хэвлэл	-	28,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,253,160.00	782,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,126,600.00	5,418,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,380,500.00	16,775,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	157,050.00	200,900.00
210502	Хоол, хүнс	9,924,500.00	15,867,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,298,950.00	706,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,750,000.00	10,620,000.00
210604	Урсгал засвар	1,750,000.00	10,620,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	300,000.00	348,700.00
210702	Дотоод албан томилолт	300,000.00	348,700.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,490,700.00	160,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,166,700.00	160,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,596,000.00	3,099,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,596,000.00	2,624,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	474,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,005,404.78	14,003,755.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,408,395.78	13,703,755.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,408,395.78	13,703,755.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,550,000.00	12,314,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,550,000.00	12,314,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,550,000.00	12,314,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,550,000.00	12,314,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	12,314,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,550,000.00)	(12,314,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/  
төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	437956500.00	424252744.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	437956500.00	411938444.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	437651500.00	411638444.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	275499600.00	269607257.40
210101	Үндсэн цалин	0.00	0.00	184769600.00	195034683.11
210102	Нэмэгдэл	0.00	0.00	61217900.00	51133775.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00	10500000.00	9884261.79
210104	Урамшуулал	0.00	0.00	19012100.00	13554536.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	39156400.00	35253554.95
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	28360400.00	24968821.99
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	2663100.00	2652538.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	2195200.00	2118365.35
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	539800.00	484488.40
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	5397900.00	5029340.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	70550500.00	70550500.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	3400000.00	3400000.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	63650500.00	62397850.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00	3500000.00	4752650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	9546200.00	7533942.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	48700.00	48700.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	899100.00	662900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	600,000.00	593,542.00
210404	Ном, хэвлэл	-	-	39,000.00	28,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	546,300.00	782,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	7,413,100.00	5,418,300.00
2105	Нормативт зардал	-	-	20,350,700.00	16,465,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	200,900.00	200,900.00
210502	Хоол, хүнс	-	-	19,744,700.00	15,867,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	405,100.00	396,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	11,000,000.00	10,620,000.00
210604	Урсгал засвар	-	-	11,000,000.00	10,620,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	-	348,700.00	348,700.00

210702	Дотоод албан томилолт	-	-	348,700.00	348,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	-	160,000.00	160,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	160,000.00	160,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	-	11,039,400.00	1,099,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	625,000.00	624,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	10,414,400.00	474,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	-	305,000.00	300,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-	305,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	305,000.00	300,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-	-	<b>12,314,300.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-	-	12,314,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	12,314,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	-	437,956,500.00	424,252,744.35
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	356,406,000.00	342,702,244.35
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	356,406,000.00	342,702,244.35
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	81,550,500.00	81,550,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	81,550,500.00	81,550,500.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

### НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>2,371,396.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>2,371,396.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	2,371,396.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	61,396.00
210401	Бичиг хэрэг	-	61,396.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	310,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	310,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	2,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	2,371,396.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	2,371,396.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	371,396.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал

татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 7 зорилтын хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

1. Хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
2. Хууль эрх зүйг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
4. Цахим сургалтын платформыг хөгжүүлэх, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн Насан туршийн боловсрол"-ыг дэмжинэ.
5. Хүүхдийг эрүүл, илчлэг сайтай хоол хүнсээр хангах
6. Төсөв санхүүгийн зөв зарцуулалт, сахилга хариуцлага
7. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд гэсэн нийт 22 арга хэмжээг хэрэгжүүлж 82.6 хувийн биелэлттэй байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 453.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал” 2008 оны Сангийн сайдын “Тушаалд хэлтэст өөрчлөлт оруулах тухай” 252 дугаар тушаалыг баримталсан. Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мян.төг /
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0.0	1637.004	-1637.004
Бараа материал	41997.4	52059.8	-10062.4
Үндсэн хөрөнгө	1226459.9	1239716.3	-13256.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1147196.5</b>	<b>1124387.05</b>	<b>22809.4</b>
<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Хуримтлагдсан үр дүн	-190257.9	422165.2	-231907.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1147196.5</b>	<b>1124387.05</b>	<b>22809.4</b>

**Авлага:** Өмнөх онд авлага үүсээгүй тайлант онд 3.08 сая төгрөгийн хувь хүнээс авах авлага, бусад зардлын тооцооллын авлага, ажилчдтай холбоотой авлага үүсэж 1.4 сая төгрөгөөр барагдуулж тайлант онд эцсийн үлдэгдэл 1.6 сая төгрөгийн авлагатай тайлагнасан байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 41.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 52.06 сая төгрөг болж өмнөх оноос 10.06 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 40.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 35.4 сая төгрөгийн бараа материал худалдан авч, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 5.2 сая төгрөгийн материал тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1.226.4 сая, эцсийн үлдэгдэл 1.239.7 сая төгрөг болж өмнөх оноос 13.2 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд

төсвийн хөрөнгөөр 12.3, дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 0.9 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд шилжүүлсэн болон акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өглөгийн дансанд оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд Улсын төсвөөс 345.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлээр улсын төсвөөс 356.4, орон нутгийн төсвөөс 81.5 сая төгрөгийг зарцуулж 13.7 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 292.8 сая төгрөг буюу 93.97 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 11.7, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 3.4, нормативд зардал 3.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нэмэлт дансанд ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 2.0 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан 0.4 сая төгрөг нийт 2.4 сая төгрөгийн орлого орж ирснээс бичиг хэргийн зардалд 0.06, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 0.3, бараа үйлчилгээний бусад зардалд 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Спортын дунд сургуулийн математикийн кабинет тохижуулахад нийт 11.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" -ыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлж ажиллаа.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган сумын спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар “Шилэн дансны тухай”, Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд нийт 148 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын анхан шатны баримтаар гүйлгээг хөөн тулган үзэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүй гүйлгээ байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, таван сая төгрөгөөс дээш орлогын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" 6.4.5-д "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "...төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн 22 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

### **3.11 Дараах аудитаар анхаарах асуудал**

Аудитаар байгууллагад хууль тогтоомжийн хэрэгжилт, анхан шатны баримтын бүрдэл талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 13.9 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 83.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг тогтоож, 13.6 сая төгрөгийн зөрчилд таслан зогсоох 3 албан шаардлага өгч, 149.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Залруулга хийсэн алдаа зөрчил илрээгүй

#### 4.2 Төлбөрийн акт

Анхан шатны баримтын бүрдэлгүй 83,600 төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоосон.

#### 4.3 Албан шаардлага

Спортын дунд сургуулийн математикийн кабинет тохижуулахад нийт 11,934,300 төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" гэсэн тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

Сургуулийн цахим сургалтын өрөөнд 1746900 төгрөгийн зурагт, хулдаас, боксын бээлий, дрож, микрофон, гэрэл, чихэвч зэрэг хөрөнгийг бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" гэсэн тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

148 Мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 6.4.8 заалтыг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Урд онд 9 мэдээлэл хоцроож мэдээлж зөвлөмж өгсөн тайлант онд алдаагаа давтан гаргасан зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

#### 4.4 Зөвлөмж

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

##### **1. Тээвэр шатахууны зардалтай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Нэмэгдсэн өртгийн албан татварын 149.0 мянган төгрөгийн баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

				/мян. төгрөгөөр/
				Үүнээс

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Спортын дунд сургууль	5	13.9	0	0	1	83.6	3	13681.2	1	149.0
	Нийт дүн	5	13.9	0	0	1	83.6	3	13681.2	1	149.0